

03



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

᠒᠐᠒1 оны 12 сарын ᠒᠗ өдөр

Дугаар 143

Номгон

Г

Г

“Сайн хөрш-хөршийн хяналтыг
хэрэгжүүлэх журам” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй хулгайлах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд архидан согтуурах, аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулах зорилгоор “Сайн хөрш-хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг олон нийтэд сурталчилахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав), хөршийн хяналтын бүлгийг байгуулж, идэвхи санаачилгатай ажиллуулах, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Б.Оюутболд)-д үүрэг болгож, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд зөвлөсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Наранбаатар)-т даалгасугай.



ДАРГА

Э.ЭНХБАТ

0121319

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн 143 дугаар тогтоолын хавсралт

**“САЙН ХӨРШ-ХӨРШИЙН ХЯНАЛТЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ ЖУРАМ”**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар иргэдийн идэвхи санаачилгад суурилан сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, өөрсдийн амьдарч буй орчиндоо амар тайван, аюулгүй орчныг бүрдүүлэх, хулгайлах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, архидан согтуурсны улмаас ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулна.

1.2. Сайн хөрш-хөршийн хяналтыг хэрэгжүүлэгч иргэд, оршин суугч нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр, энэхүү журмыг дагаж мөрдөнө

ХОЁР. ЗОРИЛГО

2.1. Баянхонгор аймгийн иргэд, оршин суугчдын идэвхи, санаачилгад суурилсан хөршийн хяналтыг бий болгож, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, хулгайн гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгаалал, архидан согтуурсны улмаас ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага болон Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

ГУРАВ.НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

3.1. “Сайн хөрш” гэж хөршийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор хамтран ажиллаж байгаа иргэдийн сайн дурын нэгдлийг.

3.2. “Хөршийн хяналт” гэж иргэд өөрсдийн амьдарч буй нутаг дэвсгэрт аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжтэй хамтран ажиллаж байгаа үйл ажиллагааг тус тус ойлгоно.

ДӨРӨВ: “САЙН ХӨРШ”-ХӨРШИЙН ХЯНАЛТЫН

БҮЛГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Орон сууц болон газар эзэмшигч /гэр хороолол/ иргэд тухайн нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан, сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж ажиллана.

4.2. Баянхонгор сумын баг бүрт хөршийн холбоо ажиллаж, энэ журамд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна. Бусад суманд энэхүү журамд нийцүүлэн хөршийн хяналтыг хэрэгжүүлнэ.

4.3. Хөршийн холбоо бүр ахлагчтай байна. Ахлагчийг гишүүдийн олонхийн саналыг үндэслэн сум, багийн Засаг дарга томилж, тус холбооны гишүүдийн мэдээллийг Цагдаагийн газарт хүргүүлнэ.

4.4. Хөршийн холбооны гишүүн болон ахлагч нь тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг гэмт хэрэг, зөрчилд холбогдож, ял эдэлж байгаагүй 21 насанд хүрсэн иргэн байна.

4.5. "Сайн хөрш"-хөршийн холбоо нь хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд гэр хорооллын болон орон сууцны оршин суугчдыг нэгтгэн салбар хөршийн холбоо байгуулж, энэхүү журамд нийцүүлэн ажиллуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

ТАВ. "САЙН ХӨРШ"-ХӨРШИЙН ХЯНАЛТЫН БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛААНЫ ЧИГЛЭЛ

5.1. Гэр хороолол, орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж, талбай, орц хонгилд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн болон гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал үүссэн талаарх мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах, нэн даруй Цагдаагийн байгууллагад мэдээлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх, холбон зуучлах, хамтран ажиллах

5.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөршийн хяналтыг хэрэгжүүлэхэд бүх шатны засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдтэй хамтран ажиллах.

5.3. Оршин суугчид өөрсдийн амьдарч буй орчны эрүүл, аюулгүй байдлыг бүрдүүлэх зорилгоор тодорхой ажлуудыг хэрэгжүүлэн зохион байгуулах.

5.4. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгаалал, хулгайн гэмт хэрэг, зөрчил, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оршин суугчдын дэмжлэгтэйгээр хамтран зохион байгуулах.

5.5. Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж буй шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны мэдэгдэл, шаардлага, зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч хариуг хугацаанд нь өгөх.

5.6. Иргэд, оршин суугчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомж сурталчлах, холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран сургалт зохион байгуулах.

5.7. Иргэд, оршин суугчдын аюулгүй байдлын орчны эрсдлийн үнэлгээ, судалгаа хийх, гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй өрх, өрх толгойлон амьдарч буй хүүхдүүдийн судалгааг гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд холбон зуучлах, холбогдох байгууллагын хамт гэрээр айлчлах

5.8. Шинэ санал санаачилга гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлэх

ЗУРГАА. "САЙН ХӨРШ"-ХӨРШИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН УДИРДЛАГААР ХАНГАХ

6.1. "Хөршийн хяналт"-ын үйл ажиллагааг дараах байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

6.2. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, сум, багийн Засаг дарга, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар өдөр тутам арга зүйн удирдлагаар хангана.

6.3. Салбар холбооны үйл ажиллагааг "Сайн хөрш"- хяналтын бүлэг болон сумын Засаг дарга, баг хариуцсан хэсгийн байцаагч нар ажлын тайланг өөрийн тайланд тусган Цагдаагийн газарт хүргүүлнэ.

6.4. Бүлгийн гишүүдэд амьдрах ухааны болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран чадавхжуулах сургалт зохион байгуулна.

ДОЛОО. "САЙН ХӨРШ"-ХӨРШИЙН ХЯНАЛТЫН БҮЛГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1. "Сайн хөрш"-хөршийн хяналтын бүлэг нь бүлгийн гишүүд, оршин суугчидтай уулзалт зохион байгуулж, гишүүдийн тоог нэмэгдүүлж болно.

7.2. Гишүүд, оршин суугч иргэдтэй уулзалт зохион байгуулж, бүлгийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх чиглэл баримтална.

7.3. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчтай тогтмол уулзалт зохион байгуулж, мэдээ, мэдээлэл солилцон хамтарч ажиллана.

7.4. Сум, багийн Засаг дарга, сууц өмчлөгчдийн холбоо, хөршийн холбоо, багийн хэсгийн байцаагч, оршин суугчидтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс хамгаалах, хууль бус үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллана.

7.5. Бүлгийн гишүүдийн утасны жагсаалтыг гаргаж, гишүүдэд анхааруулах, мэдээлэл түгээх групп үүсгэж, холбогдох байгууллага /Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар/-аас өгч буй мэдээ, мэдээллээр шуурхай хангаж, дээрх байгууллагатай мэдээлэл солилцоно.

7.6. Бүлэг нь хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган сум, багийн Засаг даргаар батлуулж, биелэлт, үр дүнг тооцон, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор Цагдаагийн газарт хүргүүлнэ.

7.7. "Сайн хөрш"-хөршийн хяналтын бүлэг нь багийн нутаг дэвсгэрт хамаарах нийтийг хамарсан арга хэмжээнд оролцож ажиллана.

7.8. Цагдаагийн байгууллагатай хамтран нийтийн болон урамшилт эргүүлийг зохион байгуулах.

7.9. Иргэд, оршин суугчдыг хууль эрх зүйн болон цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллээр тогтмол хангаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, санамж сэрэмжлүүлэг тараана.

7.10. "Сайн хөрш"-хөршийн хяналтын бүлэг нь гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гэр хорооллын гудамж, орон сууцны орц, нийтийн эзэмшлийн талбайг камержуулах, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлэх, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

НАЙМ. БҮЛГИЙН ГИШҮҮДИЙН ЭРХ ҮҮРЭГ

8.1. Иргэд, оршин суугчид өөрсдийн оршин суугаа орц, байр, гудамжаараа эвлэлдэн нэгдэж, сайн дурын үндсэн дээр "Сайн хөрш"-хөршийн хяналтын бүлэгт гишүүнээр элсэнэ.

8.2. Бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, нийтийн хэв журмыг гажуудуулахгүй байж, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд сахина.

8.3. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудад шуурхай дамжуулж иргэний үүргээ биелүүлнэ.

8.4. Нийтийн хэв журам сахихыг бусад оршин суугчдаас шаардах, бусад, оршин суугчдын саналыг хүлээн авах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар холбогдох байгууллага албан тушаалтанд мэдээлнэ.

8.5. Гэмт халдлагаас өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, өмчийг хуулийн хүрээнд хамгаалах арга хэмжээ авна.

8.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд идэвхи санаачилгатай оролцоно.

8.7. Гэр, орон байраа удаан хугацаагаар эзэнгүй орхих, бусад туслалцаа шаардлагатай талаар "Хөршийн хяналтын бүлэг"-ийн гишүүдэд мэдэгдсэн тохиолдолд туслалцаа үзүүлнэ.

8.8. Амьдрах орчны эрүүл ахуй, ариун цэврийг сайжруулах, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх бусад шаардлага тавина.

8.9. Бүлэг нь иргэд, оршин суугч, бүлгийн гишүүдээс ирүүлсэн мэдээллийн нууцлалыг хангана. Бүлгийн гишүүд нь нууцын гэрээ байгуулан ажиллана.

ЕС: ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

9.1. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран “Сайн хөрш”-хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.

9.2. “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид ажиллах чиглэлийг тогтооно.

9.3. “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллага, албан тушаалтан, аж ахуй нэгжийг татан оролцуулна.

9.4. “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагааг дэмжих, чадавхижуулах, сурталчлах, мэдээлэх, сургалт явуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх

9.5. “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх, урамшуулах

АРАВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

10.1. “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

10.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаар “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлгийн ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч шуурхай шалгаж шийдвэрлэн хариу мэдэгдэнэ.

10.3. Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил цагдаагийн байгууллагад эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, амьтан, эд зүйлийн талаар бүлгийн ахлагчийг мэдээ, мэдээллээр шуурхай хангана.

10.4 “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлгийн ахлагч, гишүүдийг чадахуулах сургалтыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтран зохион байгуулах

10.5 “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлгийн гишүүдтэй хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг тогтмол зохион байгуулах

10.6. “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагаандаа ашиглах гарын авлага, аргачилсан зөвлөмж боловсруулж, хүргүүлэх талаар удирлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах

АРВАН НЭГ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

11.1. “Сайн хөрш”-хөршийн хяналтын бүлэг, түүний гишүүдийг тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс урамшуулж болно.

11.2. "Сайн хөрш"-хөршийн хяналтын бүлэг, түүний гишүүд болон үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулсан, дэмжиж ажилласан байгууллага, албан тушаалтныг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан хэлбэрээр урамшуулна.

11.3. Идэвхи санаачилга, үр дүнтэй ажилласан бүлгийн ахлагч, гишүүн иргэдийг туршлага судлах уулзалт, хуралд зөвөлгөөнд оролцуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулна.

11.4. "Сайн хөрш"-хөршийн хяналтын бүлэгт жилд олгох урамшууллыг тухайн оны төсөвт тусган санхүүжүүлнэ.

АРВАН ХОЁР. АЖЛЫН ҮР ДҮНГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

12.1. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хор хохирол учирсан болон учирч болзошгүй талаарх мэдээллийг холбогдох байгууллагад цаг алдалгүй холбон зуучилж мэдээлсэн.

12.2. Гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр идэвхи зүтгэлтэй ажилласан.

12.3. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх үнэн бодит мэдээ, мэдээллийг тогтмол өгч ажилласан.

12.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр идэвхи зүтгэл гарган ажиллаж иргэдийн талархлыг хүлээсэн.

12.5. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран үр дүнд хүрсэн ажил зохион байгуулсан.

12.6. Багийн нутаг дэвсгэрт хамаарах нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхи санаачилгатай оролцож, иргэд, оршин суугчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон бусад сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулж, уриалсан байдал зэргийг харгалзан үзнэ.

АРВАН ГУРАВ. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

13.1. Иргэд, оршин суугч, бүлгийн гишүүд холбогдох байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан дарамт үзүүлэх, ажлын зохиомол ачаалал үүсгэхийг хориглоно.

13.2. Бүлгийн үйл ажиллагаатай холбогдуулан олж авсан мэдээ, мэдээллийн нууцлалыг задруулахыг хориглоно.

АРВАН ДӨРӨВ. ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

14.1. Хөршийн холбооны бүлгийн гишүүд эрх мэдлээ хэтрүүлэн хууль тогтоомж, журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.